МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

СОЁЛЫН ЯАМ

# О.ЖАМЬЯН ГҮНГИЙН НАЙРУУЛСАН ХЭЛ ЗҮЙН БИЧГҮҮД

# VII

УЛААНБААТАР ХОТ

2023

МОНГОЛ УЛСЫН
ЗАСГИЙН ГАЗАР

СОЁЛЫН ЯАМ

“МОНГОЛ ҮСЭГ СУРАХ БАГА ХӨВҮҮДИЙН СУРЛАГЫГ УДИРДАХ МӨРИЙН БИЧИГ ХЭМЭЭХ ЦАГААН ТОЛГОЙ ОРШИВ”

МОНГОЛ БИЧГЭЭС ГАЛИГЛАЖ, ХӨРВҮҮЛСЭН: П.ТӨРБОЛД

ХЯНАСАН: Б.СУВД

ISBN: 978-9919-0-1783-5

# МОНГОЛ ҮСЭГ СУРАХ БАГА ХӨВҮҮДИЙН СУРЛАГЫГ УДИРДАХ МӨРИЙН БИЧИГ ХЭМЭЭХ ЦАГААН ТОЛГОЙ ОРШИВ

Онходын Жамьян гүнгийн энэхүү зохиол нь нийт 30 нүүр, 15 нугалбар цаасан дээр 1927 онд барлан хэвлэсэн цагаан толгой. Модон бараар хэвд сийлүүлж Судар бичгийн хүрээлэнд хадгалуулсан гэдэг бөгөөд судлаачид 1980 он хүртэл бүрэн бүтэн байжээ хэмээн бичсэн байдаг. Жамьян гүний зохиосон хэл зүйн бичгүүд нь хэдийгээр хоорондоо адил төстэй мэт харагдавч нарийн тулгаж харвал, үзэж судлах хүмүүсийнхээ онцлогийг нэлээд бодож зохиосон болох нь харагддаг. Тухайлбал энэ зохиол нь төвөд хэл мэддэг сурагчдад тусгайлан зориулж бичсэн цагаан толгой гэдгээрээ онцлогтой.

Зохиолын агуулга: Тус зохиолынхоо эхэнд Жамьян гүн монголын анхны зохиосон нэг зуун үсэг болон хойно нэмсэн олон үсгийг хүснэгтлэн, дээр нь төвөд үсгийг бичжээ. Ингэснээр уншигч хэрэв төвөд үсэг таньдаг бол тухайн үсгийг хэрхэн зөв дуудахыг төвөггүй мэдэхэд дөхөм болгосон байна. Үүний дараа жа-гийн аймгийн долоон үсгийг онцгойлон тайлбарлажээ.

Үргэлжлүүлэн “агшлага, эгшлэг” хэмээх нэрийн учрыг товч тайлбарлав. Түүнчлэн “дан дэвсгэр, давхар дэвсгэр” үсгийн утга, хэрэглээ, эр хоёр үсэг холбох, хоёр эм үсэг холбох, эр саармаг хоёр үсэг холбох нь гэхчлэн нарийвчлан үзүүлжээ.

Бас аливаа дагах үсгийн ёс[1] хэмээх хэсэгт тийн ялгалын нөхцөлийг хэрхэн дагуулах, эр эмийг харгалзан аль хэлбэрийг хэрхэн залгаваас зохихыг ч үзүүлж, энэ тухайгаа тайлбарлахдаа “*Ер монголын олон үсэгт дунд ба адагт ороход дүр байдал хувилах ба дагах үсэг олон бөгөөд тэр бүрийн учрыг тайлбарлан гаргахад үг үсэг асар олон болох тул хүснэгт тавьж таньж мэдэхэд хялбар болгов*” гэжээ. Ингээд монгол нэг зуун дөчин хоёр үсгийг үсгийн дунд, адагт амьтай болон амьгүйгээр орох байдлыг үзүүлж, бас арван нэгэн дэвсгэр үсгийг дунд, адагт дэвсгэрлэн орох байдлыг ч тодорхой тоочжээ. “Дагах үсэг” буюу “бусдын эрхт үсэг” хэмээсний учрыг товч тайлбарлан хүснэгтээр үзүүлжээ.

Мөн “эгшиг” үсэг, “дэвсгэр” хэмээх “амьгүй үсэг”-ийн дагах ёсыг хүснэгтээр үзүүлэв. Ингээд тэдгээр үсгийнхээ хажууд төвөд үсгийг хадсан тухайд “*үүнээс дээш дэвсгэрт гаргасан арван нэгэн үсгийн дотор төвөдийн дагах үсэг лүгээ адилтгаж болох найман үсгийн оройд төвд үсэг бичиж гэрч болгов*” гээд “ *ས са ཡ йа ཝ ва гурван үсэг төвөдийн дагах үсэг лүгээ адилтгаж үл болох мэт тул эс бичив*” хэмээн тайлбарлажээ.

Үүний дараа эр үсгийг дагах ёсны тухай болон хоёр үсгийн урт ацгийг хасаж бичдэг учрыг эшлэн тайлбарласан нь: “*учир болбоос, “Алшаагийн Молом равжамба Агваандандарын зохиосон “Хэлний чимэг” хэмээх номлолд, -лүгээ, -нүгүүд хоёр үсэг болбоос дээд үсгийн сүүл мөний тул урт ацгийг хасваас зохимуй” хэмээсний тул болой*” гээд цагаан толгойн олон үсгийн дотроос анхдугаарын нэжгээд үсгийг бичигт бичих байдлыг гарган бичсэний дараа төгсгөлийн үгээ бичиж зохиолоо төгсгөжээ.

Төгсгөлийн үг: “*үүнийг Монгол улсын арван долоодугаар он бөгөөд европын нэгэн мянга есөн зуун хорин долоодугаар он, арван зургаадугаар машид гарсан хэмээх гал туулай жилд Монгол улсын Судар бичгийн хүрээлэнгийн дарга Жамьян хэмээх нэгэн*

[1] Нөхцөл дагуулах ёс.

*өвгөн зохион бичсэнийг “Монгол үсэг сурах бага хөвүүдийн сурлагыг удирдах мөрийн бичиг” хэмээн нэрийдээд хэвд сийлүүлж Судар бичгийн хүрээлэнд тавив*” хэмээсэн буй.

Жамьян гүн зохиолынхоо төгсгөлд тухайн зохиолоо хэзээ, хэнд зориулан бичсэнээ тодорхой дурддагийн адилаар 1927 онд хэвд сийлүүлэн Судар бичгийн хүрээлэнд өгснөө товч бичээд төгсгөсөн байна.



mongγol üsüg surqu baγ-a köbegüd-ün surulγ-a-yi uduridqu mör-ün bičig kemekü čaγan toluγai orosibai.

Монгол үсэг сурах бага хөвүүдийн сурлагыг удирдах мөрийн бичиг хэмээх цагаан толгой оршив



**ГАЛИГ**

01.01 ཨ a e i o u ö ü; ན na ne ni no nu nö nü;

01.02 བ ba be bi bob u bö bü; ཁ qa ke ki qo qu kö kü;

01.03 ག γa ge gi γo γu gö gü; མ ma me mi mo mu mö mü;

01.04 ལ la le li lo lu lö lü; ར ra re ri ro ru rö rü;

01.05 ས sa se si so su sö sü; ད da de di do du dö dü;

01.06 ཐ ta te ti to tu tö tü; ཇ ja je ji jo ju jö jü;

01.07 ཆ ča če či čo ču čö čü; ཡ ya ye yi yo yu yö yü;

**ХӨРВҮҮЛЭГ**

ཨ а э и о у ө ү; ན на нэ ни но ну нө нү; བ ба бэ би бо бу бө бү; ཁ ха хэ хи хо ху хө хү ; ག га гэ ги го гу гөг ү; མ ма мэ ми мо му мө мү; ལ ла лэ ли лол у лө лү; ར ра рэ ри ро ру рө рү; ས са сэ си со су сө сү; ད да дэ ди до ду дө дү; ཐ та тэ ти то ту тө тү; ཇ жа жэ жи жо жу жө жү; ཆ ча чэ чи чо чу чө чү; ཡ йа йэ йи йо йу йө йү;



**ГАЛИГ**

02.01 ཝ wa we;

02.02 ene inu mongγol-un angqan-u jokiyaγsan nigen jaγun üsüg bolai.
02.03 qoyin-a nemegsen olan üsüg bui bolbaču, man-u mongγol-un üge üsüg-tür olan-ta
02.04 kereglegseger büküi kedün üsüg-i nemejü bičiküi inu,

02.05 ཕ pa pe pi po pu pö pü; ཤ ša še ši šo šu šö šü;

**ХӨРВҮҮЛЭГ**

ва вэ;
Энэ нь Монголын анхны зохиосон нэг зуун үсэг болой. Хойно нэмсэн олон үсэг буй боловч манай монголын үг үсэгт олонтаа хэрэглэсээр бүхүй хэдэн үсгийг нэмж бичих нь, ཕ па пэ пи по пу пө пү; ཤ ша шэ ши шо шу шө шү;



## ГАЛИГ

03.01 ཛ za ze zi zo zu zö zü; ཚ ca ce ci co cu cö cü;

03.02 ལྷ lha lhe lhi lho lhu lhö lhü, ཇ ja je ji jo ju jö jü.

03.03 edeger nemegsen üsüg-ün doturaki ཇ ja- yin ayimaγ-un doluγan üsüg bolbasu, jaγun

03.04 üsüg-ün doturaki ཇ ja-yin ayimaγ-un üsüg-üd-i bičig-ün dumda ba adaγ-tur

03.05 ene metü bičikü-ber nemejü γarγaγsan üsüg bolai.

## ХӨРВҮҮЛЭГ

ཛ за зэ зи зо зу зө зү; ཚ ца цэ ци цо цу цө цү; ལྷ лха лхэ лхи лхо лху лхө лхү; ཇ жа жэ жи жо жу жө жү.

Эдгээр нэмсэн үсгийн доторх ཇ жа-гийн аймгийн долоон үсэг болбоос, зуун үсгийн доторх ཇ жа-гийн аймгийн үсгүүдийг бичгийн дунд ба адагт энэ мэт бичихээр нэмж гаргасан болой.



## ГАЛИГ

04.01 yerü mongγol-un üsüg-tür er-e kemekü čingγ-a, em-e kemekü köndei, ersü kemekü saγarmaγ
04.02 γurban ilγal bui. ali bui kemebesü,
04.03 a o u; na no nu; ba bo bu; qa qo qu;
04.04 γa γo γu; ma mo mu; la lo lu; ra ro ru;
04.05 sa so su; da do du; ta to tu; ja jo ju;
04.06 ča čo ču; ya yo yu, wa, pa po pu;

## ХӨРВҮҮЛЭГ

Ер монголын үсэгт эр хэмээх чанга, эм хэмээх хөндий, эрс хэмээх саармаг гурван ялгал буй. Аль буй хэмээвээс, а о у; на но ну; ба бо бу; ха хо ху; га го гу; ма мо му; ла ло лу; ра ро ру; са со су; да до ду; та то ту; жа жо жу; ча чо чу; йа йо йу; ва; па по пу;



## ГАЛИГ

05.01 ša šo šu; za zo zu; ca co cu; lha lho lhu; ja jo ju;
05.02 ene inu čöm er-e üsüg bolai.
05.03 e ö ü; ne nö nü; be bö bü; ge gö gü;
05.04 ke kö kü; me mö mü; le lö lü; re rö rü;
05.05 se sö sü; de dö dü; te tö tü; je jö jü;
05.06 če čö čü; ye yö yü; we, pe pö pü;

## ХӨРВҮҮЛЭГ

ша шо шу; за зо зу; лха лхо лху; жа жо жу; Энэ нь цөм эр үсэг болой. э ө ү; нэ нө нү; бэ бө бү; гэ гө гү; хэ хө хү; мэ мө мү; лэ лө лү; рэ рө рү; сэ сө сү; дэ дө дү; тэ тө тү; жэ жө жү; чэ чө чү; йэ йө йү; вэ; пэ пө пү;



## ГАЛИГ

06.01 še šö šü; ze zö zü; ce cö cü; lhe lhö lhü;
06.02 je jö jü. ene inu čöm em-e üsüg bolai.
06.03 i ni bi gi ki mi li ri si di ti ji č iyi pi ši zi
06.04 ci lhi ji, ene inu čöm saγarmaγ üsüg bolai.
06.05 er-e em-e qoyar üsüg-i nigen ügen-dür qabsurun bičijü ülü bolumui. saγarmaγ
06.06 üsüg bolbasu er-e ba em-e üsüg-ün alin-dur bolbaču qabsurun bičijü bolumui.

## ХӨРВҮҮЛЭГ

шэ шө шү; зэ зө зү; цэ цө цү; лхэ лхө лхү; жэ жө жү. Энэ нь цөм эм үсэг болой.

Эр эм хоёр нэг үгэнд хавсран бичиж үл болмуй. Саармаг үсэг болбоос эр ба эм үсгийн алинд боловч хавсран бичиж болмуй.



## ГАЛИГ

07.01 a-yin törül-ün doluγan üsüg bolbasu, bičig-ün terigün-dür yabuqu-ača
07.02 busu bičig-ün dumda ba adaγ-tur bičijü ülü bolumui. učir yaγun kemebesü,
07.03 üsüg büri a-yin egesig-tei-ber daγudaγdaqu tula egesig üsüg kememüi.
07.04 a-yin egesig büküi üsüg-i ami-tai üsüg kemen bičibei. a-yin egesig-i qasuγsan-i
07.05 inu ami ügei üsüg kemen kelejü bolumui. yambar üsüg-ün a-yin egesig-i qasuγad
07.06 ami ügei üsüg kememüi kemebesü, aliba üsüg-üd-tür debisker bolju daγaqu arban

## ХӨРВҮҮЛЭГ

а-ийн төрлийн долоон үсэг болбоос, бичгийн тэргүүнд явахаас бус бичгийн дунд ба адагт бичиж үл болмуй. Учир юун хэмээвээс, үсэг бүр а-гийн эгшигтэйгээр дуудагдах тул эгшиг үсэг хэмээмүй. а-ийн эгшиг бүхүй үсгийг амьтай үсэг хэмээн бичив. а-гийн эгшиг хассаныг нь амьгүй үсэг хэмээн хэлж болмуй. Ямар үсгийн а-ийн эгшгийг хасаад амьгүй үсэг хэмээмүй хэмээвээс, аливаа үсгүүдэд дэвсгэр болж дагах арван



## ГАЛИГ

08.01 üsüg-i ögülejüküi, tere arban üsüg ali bui kemebesü, ན na བ ba ག γa མ ma ལ la ར ra ས sa

08.02 ད da ཡ ya ཝ wa kiged ingkelig-lüge arban nige bolai. ingkelig kemegči yambar üsüg-i

08.03 ögülemüi kemebesü, mongγol-un jaγun üsüg-tür orulčaγsan ügei ང་ ng kemekü nigen

08.04 üsüg bui. tegün-i debisker-tür oruγuljuqui. γaγča γa-yin ayimaγ-ača er-e

08.05 üsüg-tür debisker bolju oruqu-yi aγsilγ-a, em-e üsüg-tür debisker bolju

08.06 oruqu-yi inu egsilge kemen ögülemüi.

## ХӨРВҮҮЛЭГ

үсгийг өгүүлжээ. Тэр арван үсэг аль буй хэмээвээс, ན на བ ба ག га མ ма ལ ла ར ра ས са ད да ཡ йа ཝ ва хийгээд инхлэг лүгээ арван нэг болой. Инхлэг хэмээгч ямар үсгийг өгүүлмүй хэмээвээс, монголын зуун үсэгт оролцсонгүй ང་-нг хэмээх нэгэн үсэг буй. Түүнийг дэвсгэрт оруулжээ. Гагц га-гийн аймгаас эр үсэгт дэвсгэр болж орохыг агшлага, эм үсэгт дэвсгэр болж орохыг нь эгшлэг хэмээн өгүүлмүй.



**ГАЛИГ**

09.01 bügüde üsüg-üd-tür dang debisker ögkü inu,
09.02 an nan ban qan; ab nab bab qab; aγ naγ baγ qaγ;
09.03 am nam bam qam; al nal bal qal; ar nar bar qar;
09.04 as nas bas qas; ad nad bad qad; ay nay bay qay;
09.05 aw naw baw qaw; ang nang bang qang; eg neg beg keg;
09.06 basa ya debisker-ün door-a ན na ག γa མ ma ལ la ར ra ས sa ད da ene doluγan üsüg-i debisčü

**ХӨРВҮҮЛЭГ**

бүгд үсгүүдэд дан дэвсгэр өгөх нь, ан нан бан хан; аб наб баб хаб; аг наг баг хаг; ам нам бам хам; ал нал бал хал; ар нар бар хар; ас нас бас хас; ад над бад хад; ай най бай хай; ав нав бав хав; анг нанг банг ханг; эг нэг бэг хэг; бас йа дэвсгэрийн доор ན на ག га མ ма ལ ла ར ра ས са ང да долоон үсгийг дэвсэж



**ГАЛИГ**

10.01 dabqur debisker kemedeg bui. ali bui kemebesü,
10.02 ayin nayin bayin qayin; ayiγ nayiγ bayiγ qayiγ;
10.03 ayim nayim bayim qayim; ayil nayil bayil qayil;
10.04 ayir nayir bayir qayir; ayis nayis bayis qayis;
10.05 ayid nayid bayid qayid; edeger bolai.
10.06 basa er-e qoyar üsüg qolbuqu anu,

**ХӨРВҮҮЛЭГ**

давхар дэвсгэр хэмээдэг буй. Аль буй хэмээвээс, айин найин байин хайин; айиг найиг байиг хайиг; айим найим байим хайим; айил найил байил хайил; айир найир байир хайир; айис найис байис хайис; айид найид байид хайид; эдгээр болой. Бас эр хоёр үсэг холбох нь,



## ГАЛИГ

11.01 an-a nan-a ban-a qan-a; aba naba baba qaba; aq-a naq-a baq-a qaq-a;
11.02 aγ-a naγ-a baγ-a qaγ-a; ama nama bama qama; ala nala bala qala;
11.03 ar-a nar-a bar-a qar-a; asa nasa basa qasa; ada nada bada qada;
11.04 aja naja baja qaja; ača nača bača qača; ay-a nay-a bay-a qay-a;
11.05 au-a nau-a bau-a qau-a; awa nawa bawa qawa; edeger bolai.
11.06 qoyar em-e üsüg qolbuqu anu, ege nege bege kege,

## ХӨРВҮҮЛЭГ

ан-а нан-а бан-а хан-а; аба наба баба хаба; ах-а нах-а бах-а хах-а; аг-а наг-а баг-а хаг-а; ама нама бама хама; ала нала бала хала; ар-а нар-а бар-а хар-а; аса наса баса хаса; ада нада бада хада; ажа нажа бажа хажа; ача нача бача хача; ай-а най-а бай-а хай-а; ау-а нау-а бау-а хау-а; ава нава бава хава; эдгээр болой. Хоёр эм үсэг холбох нь эгэ нэгэ бэгэ хэгэ;



**ГАЛИГ**

12.01 er-e saγarmaγ qoyar üsüg qolbuqu anu,
12.02 ani nani bani qani; abi nabi babi qabi; agi nagi bagi qagi;
12.03 ami nami bami qami, ali nali bali qali; ari nari bari qari;
12.04 asi nasi basi qasi; adi nadi badi qadi; aji naji baji qaji,
12.05 ači nači bači qači; edeger bolai.
12.06 basa aliba daγaqu üsüg-ün yosun kemebesü,

**ХӨРВҮҮЛЭГ**

Эр саармаг хоёр үсэг холбох нь, ани нани бани хани; аби наби баби хаби; аги наги баги хаги; ами нами бами хами; али нали бали хали; ари нари бари хари; аси наси баси хаси; ади нади бади хади; ажи нажи бажи хажи; ачи начи бачи хачи эдгээр болой. Бас аливаа дагах үсгийн ёс хэмээвээс,



## ГАЛИГ

13.01 -yi -yin -bar -ban, ene dörbe bolbasu, ya wa qoyar debisker ba, debisker ügei
13.02 ami-tai üsüg bügüde-yi daγamui. -u ene bolbasu γaγča na debisker
13.03 üsüg-i daγamui, -i -iyar -iyan, ene γurba bolbasu ya wa qoyar-ača busud
13.04 debisker üsüg bügüde-yi daγamui. -i, bolbasu na ya wa γurba-ača busud
13.05 debisker üsüg bügüde-yi daγamui. -taγan -tegen -tur γurba bolbasu ba γa
13.06 ra sa da, ene tabun üsüg-i debiskerlejü oruqui-dur daγamui. -daγan -degen -dur,

## ХӨРВҮҮЛЭГ

-йи -йин -бар -бан энэ дөрөв болбоос, йа ва хоёр дэвсгэр ба дэвсгэргүй амьтай үсэг бүгдийг дагамуй. -у энэ болбоос гагц на дэвсгэр үсгийг дагамуй. -и -ийар -ийан энэ гурав болбоос йа ва хоёроос бусад дэвсгэр үсэг бүгдийг дагамуй. -и болбоос на йа ва гурваас бусад дэвсгэр үсэг бүгдийг дагамуй. -таган -тэгэн -тур болбоос ба га ра са да энэ таван үсгийг дэвсгэрлэж ороход дагамуй. -даган -дэгэн -дур



## ГАЛИГ

14.01 γurba bolbasu ba γa ra sa da tabu-ača busud debisker üsüg ba debisker ügei
14.02 ami-tai üsüg bügüde-yi daγamui.
14.03 basa dakin ilγabasu, -daγan -taγan anu -luγ-a -nuγud, ene tabu bolbasu,
14.04 čöm er-e üsüg-i daγamui. -tegen -degen inu -lüge -nügüd, ene tabu bolbasu,
14.05 čöm em-e ba saγarmaγ üsüg bügüde-yi daγamui.
14.06 yerü mongγol-un olan üsüg-tür dumda ba adaγ-tur oruqui-dur düri bayidal

## ХӨРВҮҮЛЭГ

гурав болбоос ба га ра са да энэ таваас бусад дэвсгэр үсэг ба дэвсгэргүй амьтай үсэг бүгдийг дагамуй. Бас дахин ялгаваас, -даган -таган ану -лугаа -нугууд энэ тав болбоос, цөм эр үсгийг дагамуй. -тэгэн -дэгэн ину -лүгээ -нүгүүд энэ тав болбоос цөм эм үсэг бүгдийг дагамуй. Ер монголын олон үсэгт дунд ба адагт ороход дүр байдал



**ГАЛИГ**

15.01 qubilqu ba, daγaqu üsüg olan böged, tere büri-yin učir-i
15.02 tayilburilan γarγaqui-dur üge üsüg asuru olan bolqu tula küsünüg-tür
15.03 talbiju taniju medeküi-dür kilbar bolγabai.
15.04 egün-eče degegsi mongγol-un nigen jaγun döčin qoyar üsüg-i aliba üsüg-ün
15.05 dumda ami-tai-bar oruqu bayidal-i üjegülküi-dür eyin buyu.
15.06 ན -na- -ne- -ni- -no- -nu- -nö- -nü-; བ -ba- -be- -bi- -bo- -bu- -bö- -bü-;

**ХӨРВҮҮЛЭГ**

хувилах ба дагах үсэг олон бөгөөд тэр бүрийн учрыг тайлбарлан гаргахад үг үсэг асар олон болох тул хүснэгт тавьж таньж мэдэхэд хялбар болгов.
Үүнээс дээш монгол нэг зуун дөчин хоёр үсгийг аливаа үсгийн дунд амьтайгаар орох байдлыг үзүүлэхэд ийн буюу. ན -на- -нэ- -ни- -но- -ну- -нө- -нү-; བ -ба- -бэ- -би- -бо- -бу- -бө- -бү-;



## ГАЛИГ

16.01 ཁ -qa- -ke- -ki- -qo- -qu- -kö- -kü-; ག -γa- -ge- -gi- -γo- -γu- -gö- -gü-;

16.02 མ -ma- -me- -mi- -mo- -mu- -mö- -mü-; ལ -la- -le- -li- -lo- -lu- -lö- -lü-;

16.03 ར -ra- -re- -ri- -ro- -ru- -rö- -rü-; ས -sa- -se- -si- -so- -su- -sö- -sü-;

16.04 ད -da- -de- -di- -do- -du- -dö- -dü-; ཐ -ta- -te- -ti- -to- -tu- -tö- -tü-;

16.05 ཇ -ja- -je- -ji- -jo- -ju- -jö- -jü-; ཆ -ča- -če- -či- -čo- -ču- -čö- -čü-;

16.06 ཡ -ya- -ye- -yi- -yo- -yu- -yö- -yü-; ཝ -wa- -we-;

## ХӨРВҮҮЛЭГ

ཁ -ха- -хэ- -хи- -хо- -ху- -хө- -хү-; ག -га- -гэ- -ги- -го- -гу- -гө- -гү-; མ -ма- -мэ- -ми- -мо- -му- -мө- -мү-; ལ -ла- -лэ- -ли- -ло- -лу- -лө- -лү-; ར -ра- -рэ- -ри- -ро- -ру- -рө- -рү-; ས -са- -сэ- -си- -со- -су- -сө- -сү-; ད -да- -дэ- -ди- -до- -ду- -дө- -дү-; ཐ -та- -тэ- -ти- -то- -ту- -тө- -тү-; ཇ -жа- -жэ- -жи- -жо- -жу- -жө- -жү-; ཆ -ча- -чэ- -чи- -чо- -чу- -чө- -чү-; ཡ -йа- -йэ- -йи- -йо- -йу- -йө- -йү-; ཝ -ва- -вэ-;



## ГАЛИГ

17.01 ཕ -pa- -pe- -pi- -po- -pu- -pö- -pü-; ཤ -ša- -še- -ši- -šo- -šu- -šö- -šü-

17.02 ཟ -za- -ze- -zi- -zo- -zu- -zö- -zü-; ཚ -ča- -če- -či- -čo- -ču- -čö- -čü;

17.03 ལྷ -lha- -lhe- -lhi- -lho- -lhu- -lhö- -lhü-; edeger bolai.
17.04 basa edeger üsüg-i aliba üsüg-ün adaγ-tur ami-tai-bar oruqu bayidal-i
17.05 üjegülküi-dür eyin buyu.

17.06 ན -n-a -n-e -ni -no -nu -nö -nü; བ -ba -be -bi -bo -bu -bö -bü;

## ХӨРВҮҮЛЭГ

ཕ -па- -пэ- -пи- -по- -пу- -пө- -пү-; ཤ -ша- -шэ- -ши- -шо- -шу- -шө- -шү-; ཟ -за- -зэ- -зи- -зо- -зу- -зө- -зү-; ཚ -ца- -цэ- -ци- -цо- -цу- -цө- -цү; ལྷ -лха- -лхэ- -лхи- -лхо- -лху- -лхө- -лхү- эдгээр болой. Бас эдгээр үсгийг аливаа үсгийн адагт амьтайгаар орох байдлыг үзүүлэхэд ийн буюу. ན -н-а -н-э -ни -но -ну -нө -нү; བ -ба -бэ -би -бо -бу -бө -бү;



## ГАЛИГ

18.01 ཁ -q-a -ke -ki -qo -qu -kö -kü; ག -γ-a -ge -gi -γo -γu -gö -gü;

18.02 མ -ma -me -mi -mo -mu -mö -mü; ལ -la -le -li -lo -lu -lö -lü;

18.03 ར -r-a -r-e -ri -ro -ru -rö -rü; ས -sa -se -si -so -su -sö -sü;

18.04 ད -da -de -di -do -du -dö -dü; ཐ -ta -te -ti -to -tu -tö -tü;

18.05 ཇ -ja -je -ji -jo -ju -jö -jü; ཆ -ča -če -či -čo -ču -čö -čü;

18.06 ཡ -y-a -y-e -yi -yo -yu -yö -yü; ཝ -u-a -u-e; wa we;

## ХӨРВҮҮЛЭГ

ཁ -х-а -хэ -хи -хо -ху -хө -хү; ག -г-а -гэ -ги -го -гу -гө -гү; མ -ма -мэ -ми -мо -му -мө -мү; ལ -ла -лэ -ли -ло -лу -лө -лү; ར -р-а -р-э -ри -ро -ру -рө -рү; ས -са -сэ -си -со -су -сө -сү; ད -да -дэ -ди -до -ду -дө -дү; ཐ -та -тэ -ти -то -ту -тө -тү; ཇ -жа -жэ -жи -жо -жу -жө -жү; ཆ -ча -чэ -чи -чо -чу -чө -чү; ཡ -й-а -й-э -йи -йо -йу -йө -йү; ཝ -у-а -у-э; ва вэ;



## ГАЛИГ

19.01 པ -pa -pe -pi -po -pu -pö -pü; ཤ -ša -še -ši -šo -šu -šö -šü;

19.02 ཛ -za -ze -zi -zo -zu -zö -zü; ཚ -ča -če -či -čo -ču -čö -čü;

19.03 ལྷ -lha -lhe -lhi -lho -lhu -lhö -lhü; edeger bolai.

19.04 basa deger-e ögülegsen na terigüten arban nigen üsüg-i aliba bičig-ün dumda

19.05 debiskerlen oruqu bayidal-i üjegülküi-dür emüneki suγum-dur ami-tai-bar bičijü gereči

## ХӨРВҮҮЛЭГ

པ -па -пэ -пи -по -пу -пө -пү; ཤ -ша -шэ -ши -шо -шу -шө -шү; ཛ -за -зэ -зи -зо -зу -зө -зү; ཚ -ча -чэ -чи -чд -чу -чө -чү; ལྷ -лха -лхэ -лхи -лхо -лху -лхө -лхү эдгээр болой. Бас дээр өгүүлсэн на тэргүүтэн арван нэгэн дэвсгэр үсгийг аливаа бичгийн дунд дэвсгэрлэн орох байдлыг үзүүлэхэд өмнөх шугамд амьтайгаар бичиж гэрч



**ГАЛИГ**

20.01 bolγabai. daraγ-a suγum-dur ami ügei debiskerlekü bayidal-i üjegülbei.

20.02 ན na བ ba ག γa མ ma ལ la ར ra ས sa ད da ཡ ya ཝ wa ང ng

20.03 -n- -b- -γ- -m- -l- -r- -s- -d- -y- -w- -ng-,
20.04 adaγ-tur oruqu bayidal anu,
20.05 -n -b -γ -m -l -r -s -d -y -w -ng, edeger bolai.

**ХӨРВҮҮЛЭГ**

болгов. Дараа шугамд амьгүй дэвсгэрлэх байдлыг үзүүлэв. ན на བ ба ག га མ ма ལ ла ར ра ས са ད да ཡ йа ཝ ва ང ng, -н- -б- -г- -м- -л- -р- -с- -д- -й- -у- -нг-, адагт орох байдал нь -н -б -г -м -л -р -с -д -й -в -нг, эдгээр болой.



## ГАЛИГ

21.01 basa degedü üsüg-tür nöküčel bolju üge bolγaqu olan üsüg bui. tedeger-i
21.02 daγaqu üsüg kememüi. basa busud-un erketü üsüg čü kemedeg bui. yaγun-u
21.03 tula busud-un erketü üsüg kememüi kemebesü, degedü üsüg-tür nöküčel
21.04 bolju üge bolγaqu böged, terigün-dür bičigdeged üge bolγaju čidaqu ügei
21.05 tula busud-un erketü üsüg kemebei.
21.06 ali üsüg mön yambar üsüg-tür daγaqu yosun-i küsünüg-tür talbisuγai.

## ХӨРВҮҮЛЭГ

Бас дээд үсэгт нөхцөл болж үг болгох олон үсэг буй. Тэдгээрийг дагах үсэг хэмээмүй. Бас бусдын эрхт үсэг ч хэмээдэг буй. Юуны тул бусдын эрхт үсэг хэмээмүй хэмээвээс, дээд үсэгт нөхцөл болж үг болгох бөгөөд тэргүүнд бичигдээд үг болгож чадахгүй тул, бусдын эрхт үсэг хэмээв. Аль үсэг мөн ямар үсэгт дагах ёсыг хүснэгт тавьсугай.



## ГАЛИГ

22.01 ཨན་ an-a -yi -yin -bar -ban -dur- daγan

22.02 ཨབ་ aba -yi -yin -bar -ban -dur -daγan

22.03 ཨཁ་ aq-a -yi -yin -bar -ban -dur -daγan

22.04 ཨག་ aγ-a -yi -yin -bar -ban -dur -daγan

22.05 ཨམ་ ama -yi -yin -bar -ban -dur -daγan

22.06 ཨལ་ ala -yi -yin -bar -ban -dur -daγan

22.07 ཨར་ ar-a ara -yi -yin -bar -ban -dur -daγan

## ХӨРВҮҮЛЭГ

ཨན་ ан-а -йи -йин -бар -бан -дур -даган; ཨབ་ аба -йи -йин -бар -бан -дур -даган; ཨཁ་ ах-а -йи -йин -бар -бан -дур -даган; ཨག་ аг-а -йи -йин -бар -бан -дур -даган; ཨམ་ ама -и -йин -бар -бан -дур -даган; ཨལ་ ала -йи -йин -бар -бан -дур -даган; ཨར་ ар-а ара -йи -йин -бар -бан -дур -даган;



## ГАЛИГ

23.01 ཨས་ asa -yi -yin -bar -ban -dur -daγan

23.02 ཨད་ ada -yi -yin -bar -ban -dur -daγan

23.03 ཨཐ་ ata -yi -yin -bar -ban -dur -daγan

23.04 ཨཛ་ aja -yi -yin -bar -ban -dur -daγan

23.05 ཨཚ་ ača -yi -yin -bar -ban -dur -daγan

23.06 ཨཡ་ ay-a -yi -yin -bar -ban -dur -daγan

23.07 ཨཝ་ aw-a awa -yi -yin -bar -ban -dur -daγan

## ХӨРВҮҮЛЭГ

ཨས་ аса -йи -йин -бар -бан -дур -даган; ཨད་ ада - йи -йин -бар -бан -дур -даган; ཨཐ་ ата -йи -йин -бар -бан -дур -даган; ཨཛ་ ажа - йи -йин -бар -бан -дур -даган; ཨཚ་ ача -йи -йин -бар -бан -дур -даган; ཨཡ་ ай-а -йи -йин -бар -бан -дур -даган; ཨཝ་ ау-а -йи -йин -бар -бан -дур -даган;



## ГАЛИГ

24.01 ene inu kedüken tedüi-yi bičigsen bolbaču egesig-tei üsüg bügüde-yi daγaqu üsüg
24.02 ene bolai. egesig kemegči yambar üsüg-i ögülemüi kemebesü a-yin egesig büküi
24.03 ami-yai üsüg mön bolai. a-yin egesig-i qasuγsan debisker kemekü ami ügei
24.04 üsüg-i daγaqu yosun-i küsünüg-tür talbiγsan eyin buyu.

24.05 ཨན་ an -i -u -iyar -iyan -dur -daγan

24.06 ཨམ་ am -i -un -iyar -iyan -dur -daγan

## ХӨРВҮҮЛЭГ

Энэ нь хэдхэн төдийг бичсэн боловч эгшигтэй үсэг бүгдийг дагах үсэг энэ болой. Эгшиг хэмээгч ямар үсгийг өгүүлмүй хэмээвээс, а-гийн эгшиг бүхүй амьтай үсэг мөн болой. А-гийн эгшгийг хассан дэвсгэр хэмээх амьгүй үсгийг дагах ёсыг хүснэгт тавиваас ийн буюу. ཨན་ ан -и -у -ийар -ийан -дур -даган; ཨམ་ ам -и -ун -ийар -ийан -дур -даган;




## ГАЛИГ

25.01 ཨལ་ al -i -un -iyar -iyan -dur -daγan

25.02 ཨང་ ang -i -un -iyar -iyan -dur -daγan

25.03 ཨག་ aγ -i -un -iyar -iyan -tur -taγan

25.04 ཨད་ ad -i -un -iyar -iyan -tur -taγan

25.05 ཨབ་ ab -i -un -iyar -iyan -tur -taγan

25.06 ཨར་ ar -i -un -iyar -iyan -tur -taγan
25.07 as -i -un -iyar -iyan -tur -taγan

## ХӨРВҮҮЛЭГ

ཨལ་ ал -и -ун -ийар -ийан -дур -даган; ཨང་ анг -и -ун -ийар -ийан -дур -даган; ཨག་ аγ -и -ун -ийар -ийан -тур -таган; ཨད་ ад -и -ун -ийар -ийан -тур -таган; ཨབ་ аб -и -ун -ийар -ийан -тур -таган; ཨར་ ар -и -ун -ийар -ийан -тур -таган; ас -и -ун -ийар -ийан -тур -таган;



## ГАЛИГ

26.01 ay -yi -yin -bar -ban -dur -daγan
26.02 aw -yi -yin -bar -ban -dur -daγan
26.03 egün-eče degegsi debisker-tür γarγaγsan arban nigen üsüg-ün dotur-a töbed-ün
26.04 daγaqu üsüg-lüge adalidqaju bolqu naiman üsüg-ün orui-dur töbed üsüg
26.05 bičijü gereči bolγabai. ས sa ཡ ya ཝ wa γurban üsüg töbed-ün daγaqu üsüg-lüge
26.06 adalidqaju ülü bolqu metü tula ese bičibei.

## ХӨРВҮҮЛЭГ

ай -йи -йин -бар -бан -дур -даган; ау -йи -йин -бар -бан -дур -даган; Үүнээс дээш дэвсгэрт гаргасан арван нэгэн үсгийн дотор төвдийн дагах үсэг лүгээ адилтгаж болох найман үсгийн оройд төвд үсэг бичиж гэрч болгов. ས са ཡ йа ཝ ва гурван үсэг төвөдийн дагах үсэг лүгээ адилтгаж үл болох мэт тул эс бичив.



## ГАЛИГ

27.01 er-e üsüg-i daγaqu yosun-i küsünüg-tür talbiju üjegülsügei.
27.02 ན na anu -luγ-a -nuγud -daγan -taγan
27.03 ནོ no anu -luγ-a -nuγud -daγan -taγan[2]
27.04 ནོ nu anu -luγ-a -nuγud -daγan -taγan
27.05 em-e ba, saγarmaγ üsüg-i daγaqu yosun anu,
27.06 ནེ ne inu -lüge -nügüd -degen -tegen

## ХӨРВҮҮЛЭГ

Эр үсгийг дагах ёсыг хүснэгт тавьж үзүүлсүгэй. ན на ану -лугаа -нугууд -даган -таган; ནོ но ану -лугаа -нугууд -даган -таган; ནོ ну ану -лугаа -нугууд -даган -таган; Эм ба саармаг үсгийг дагах ё

[2] Төвөд үсгийн “ni” байваас зохих мэт.



## ГАЛИГ

28.01 ནོ nö inu -lüge -nügüd -degen -tegen

28.02 ནུ nü inu -lüge -nügüd -degen -tegen

28.03 ནི ni inu -lüge -nügüd -degen -tegen

28.04 -lüge -nügüd qoyar üsüg-ün urtu ačuγ-i qasuγsan učir bolbasu, alaša-yin monlam

28.05 rabjamba aγwang dandar-un jokiyaγsan kelen-ü čimeg kemekü nomlal-dur -lüge -nügüd qoyar

28.06 üsüg bolbasu degedü üsüg-ün segül mön-ü tula urtu ačuγ-i qasubasu jokimui.

## ХӨРВҮҮЛЭГ

ནོ нө ину -лүгээ -нүгүүд -дэгэн -тэгэн; ནུ нү ину -лүгээ -нүгүүд -дэгэн -тэгэн; ནི ни ину -лүгээ -нүгүүд -дэгэн -тэгэн; -лүгээ -нүгүүд хоёр үсгийн урт ацгийг хассан учир болбоос, Алшаагийн Молом равжамба Агваандандарын зохиосон "Хэлний чимэг" хэмээх номлолд, -лүгээ, -нүгүүд хоёр үсэг болбоос дээд үсгийн сүүл мөний тул урт ацгийг хасваас зохимуй.



**ГАЛИГ**

29.01 kemegsen-ü tula bolai.
29.02 basa čaγan toluγai-yin olan üsüg-ün doturača angqaduγar-un nijeged üsüg-i
29.03 bičig-tür bičikü bayidal-i γarγan bičisügei.
29.04 a na ba qa γa ma la ra sa da ta ja ča ya wa kiged, pa ša za ca lha,
29.05 edeger bolai. kemegsen egün-i mongγol ulus-un arban doluduγar on böged,
29.06 ibropa-yin nigen mingγan yisün jaγun qorin doluduγar on, arban jirγuduγar masida

**ХӨРВҮҮЛЭГ**

хэмээсний тул болой. Бас Цагаан толгойн олон үсгийн дотроос анхдугаарын нэжгээд үсгийг бичигт бичих байдлыг гарган бичсүгэй. а на ба ха га ма ла ра са да та жа ча йа ва хийгээд па ша за ца лха эдгээр болой хэмээсэн үүнийг Монгол улсын арван долоодугаар он бөгөөд европын нэгэн мянга есөн зуун хорин долоодугаар он, арван зургаадугаар машид



## ГАЛИГ

30.01 γaruγsan kemekü γal taulai jil-dür mongγol arad ulus-un sudur bičig-ün küriyeleng-ün
30.02 daruγ-a jamyang kemekü nigen ebügen jokiyan bičigsen-i, mongγol üsüg surqu baγ-a
30.03 köbegüd-ün surulγ-a-yi uduridqu mör-ün bičig kemen nereyidüged, keb-tür
30.04 seyilegüljü sudur bičig-ün küriyeleng-dür talbibai.

## ХӨРВҮҮЛЭГ

гарсан хэмээх гал туулай жилд Монгол ард улсын Судар бичгийн хүрээлэнгийн дарга Жамьян хэмээх нэгэн өвгөн зохион бичсэнийг “Монгол үсэг сурах бага хөвүүдийн сурлагыг удирдах мөрийн бичиг” хэмээн нэрийдээд хэвд сийлүүлж Судар бичгийн хүрээлэнд тавив.

Ашигласан ном

Ринчен. Б. (2015). Монгол бичгийн хэлний зүй. Тэргүүн дэвтэр. Удиртгал. Эрхлэн хэвлүүлсэн Э.Пүрэвжав, Улаанбаатар: Соёмбо принтинг. 115 тал.

Пүрэвжав. Э. (2014). Их эрдэмтэн Онходын Жамьян. Хянан тохиолдуулсан Б.Энхтүвшин, Улаанбаатар: Адмон принтинг. 138-157 тал.

Жамьян О. (2014). Монгол хэл бичгийн ухаан. Эмхэтгэн хэвлүүлсэн Э.Пүрэвжав. хянан тохиолдуулсан Д.Төмөртогоо, Улаанбаатар: Адмон принтинг. 19-39, 121-255 тал

Төмөртогоо. Д. (1982). Монгол хэл шинжлэлийн түүхэн уламжлал ба онолын үндэс. “Хэл зохиол судлал” XVII боть, V дэвтэр, Улаанбаатар, 32-81 тал.